

**ДАРХАН-УУЛ АЙМАГ
“МӨНХБОЛОР-ЭРДЭНЭ”
ХХК**

**2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

1. КОМПАНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.2 ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМЫН ТАЛААР АВАХ
АРГА ХЭМЖЭЭ

3.4 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНОО ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

3.5 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

3.6 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД,
ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ БИЕЛЭЛТ

4. БОМТ-ИЙ БИЕЛЭЛТИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Зургийн жагсаалт

Зураг 1 Шохойн чулуу шатаах зуух

Зураг 2 Модны суулгац

Зураг 3 Модны суулгац

Зураг 4 Модны суулгац

Зураг 5 Модны суулгац тарилт

Зураг 5 Хөрсний ус чийгийн нөөцийг хамгаалах зөв зохистой ашиглалт

Зураг 5 тарилт хийх зөвлөмж

Зураг 6 Хог хаягдлын менежмент

Зураг 7-8 Хог хаягдлын сургалтын материал

Зураг 9—10 Хог хаягдлын ангилал

Зураг 11-12 Орчны шинжилгээний хэмжилт хийж байгаа нь

Зураг 13 Шинжилгээний дүн

Зураг 14-15 БОМТайланг тайлагнаж байгаа байдал

Хүснэгт 1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авах арга хэмжээ

Хүснэгт 2 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авах арга хэмжээ

Хүснэгт 3 Хөрсний ус чийгийн нөөцийг хамгаалах зөв зохистой ашиглалт

Хүснэгт 4 Хог хаягдлын сургалтын хуваарь

Хүснэгт 5 Оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН НЭР

“Шийрийн хөндийн шохойн чулууны орд ашиглах”

1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Шийрийн хөндийн шохойн чулууны ордыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглахад төслийн зорилготой оршино.

1.3 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН НЭР

“Мөнхболор-Эрдэнэ” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011190140

Регистрийн дугаар: 5314593

1.4 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 1 дугаар хороо, 2-р хороолол, 60-9 тоот,

Утас: 9908-5479

1.5 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Дархан уул аймгийн Хонгор сумын Шийрийн хөндийд 33,57 га талбай бүхий газар, Дархан сумаас зүүн урагш 4,5 км зайд байрладаг

Солбицол: **Хүснэгт 1**

| № | Х | У |
|----------|---------------|---------------|
| 1 | 106° 2' 41.23 | 49° 27' 15.93 |
| 2 | 106° 2' 41.23 | 49° 27' 1.93 |
| 3 | 106° 3' 11.24 | 49° 27' 1.93 |
| 4 | 106° 3' 11.24 | 49° 26' 51.93 |
| 5 | 106° 2' 31.23 | 49° 26' 51.93 |
| 6 | 106° 2' 31.23 | 49° 27' 15.93 |

Зураг 1 ШОХОЙН ЧУЛУУ ШАТААХ ЗУУХ



Шохой шатаах Бэюу



шатаасан шохой буюу барилгын шохой

а) Үйлдвэрийн танилцуулга

- “Мөнхболор-Эрдэнэ” ХХК нь 2012 оны 05-р сард Шохойн чулуу баяжуулах үйлдвэрт шохой шатаах үндсэн чиглэлтэйгээр ашиглалтанд орсон .
- Жил бүр татвар төлдөг, татвар төлөгч байгууллага юм.
- Одоогийн байдлаар нийт 20 ажилтан албан хаагчидтай, ажиллах хүчний 80 гаруй хувь нь 20-35 насны залуучууд байдаг.
- Дархан-Уул аймгийн Дархан сумын Шийрийн хөндийт 33,57 га газарыг Ашигт малтмалын газрын “АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” MV-017041 дугаартай зөвшөөрлийг ашиглаж байна.


б) Төслийн талбайн зохион байгуулалтууд, барилга байгууламжууд, бүтцийн товч танилцуулга

- Ил уурхай: Ил уурхайн дотоод зам овоолгууд
- Баяжуулах үйлдвэр: Шохойн чулууг баяжуулах үйлдвэр
- Засвар үйлчилгээний хэсэг: засварын алба, сэлбэг хэрэгслийн агуулах,

ШТМ-ын агуулах

- Уурхайн тосгон: Ажлчдын байр, хоолны газар
- Уурхайн дэд бүтэц: Усан хангамж, цахилгаан хангамж

Шохойн үйлдвэрийн технологийн бүдүүвч



в) Төслийн хэрэгжих орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжлийн түвшин

1. Инженерийн байгууламж:

Тээвэрлэлт :

- Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу жилд хамгийн ихдээ 117,4 мян.м3 хөрс хуулж, 50,0 мянган шохойн чулуу олборлоно
- Уулын ажлаар хуулах хөрсийг гадаад овоолгын талбайд тээвэрлэнэ. Хөрсний тээврийн зай дундажаар 0,6 км болно. Мөн дөрөвдөгч худаснаас үржил шимт хөрсийг хуулан зурагт үзүүлсний дагуу овоолно.
- Шохойн чулууг агуулахын талбай хүртэл 0,6 км зайнд тээвэрлэнэ.
- Уурхайн гадаад вээрийн зам шийрийн хөндийн шохойн чулууны ил уурхайгаас олборлосон шохойн чулууг уурхайн дэргэдэх тоосго шатаах баюунд шатаах

Цахилгаан хангамж:

Шийрийн хөндийн шохойн чулууны орд нь дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших бөгөөд Хонгор сумын төвөөс өндөр хүчдлийн цахилгаан шугамаар цахилгаан эрчим хүчээр хангагдаж байгаа.

Харилцаа холбоо:

- Энэ бүс нутаг нь харилцаа холбооны бүх сүлжээнд холбогдсон. Бусад суурин газруудтай үүрэн холбоогоор холбогдох бөгөөд уурхайн дотоод хэрэгцээнд богино долгионы станцаар холбоо барина

2. Зам байгууламж:

- Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших “Шийрийн хөндийн шохойн чулууны орд” газар нь Дархан сумаас зүүн урагш 4,5 км, Улаанбаатар хотоос 236 км зайтай оршдог. Улсын чанартай авто болон төмөр замын 11 км орчим алслагдсан бөгөөд эдгээр замуудад сайжруулсан шороон замаар холбогдоно.

.БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭС

Монгол улсын "Байгаль орчныг хамгаалах тухай", "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай", "Газрын тосны бүтээгдэхүүний тухай", "Газрын тосны тухай", "Галын аюулгүй байдлын тухай", "Хэмжпийн нэгдмэл байдлыг хангах тухай", "Барилгын тухай", "Ариун цэврийн тухай", "Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай", "Химийн хорт бодисоос хамгаалах тухай", "Авто тээврийн тухай" хуулиуд болон Засгийн Газар, БОАЖЯ болон бусад яамнаас гаргасан холбогдох заавар журмын дагуу боловсруулав. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн байгаль орчныг хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан бөгөөд одоогийн төлөвлөсөн хүчин чадлын хэмжээнд үйл ажиллагаа явуулах хугацаанд уг төлөвлөгөө хүчин төгөлдөр байна.

- Байгаль орчин, техник технологийн асуудал
- Төслийн үндсэн үйл ажиллагаа

Төслөөс гарах хаягдлыг хадгалах, зайлуулах, орчны бохирдлыг багасгах, гал түймэр болон бусад осол аюулаас сэргийлэх арга технологийг тайлангийн зохих хэсгүүдэд тусгасан болно.

- Байгаль орчин-нийгэм, эдийн засгийн асуудал
Төсөл хэрэгжсэнээр орон нутгийн иргэд ажлын байраар хангагдахын зэрэгцээ орон нутгийн төсөвт тодорхой хувь нэмэр оруулна.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээх, байгаль хамгаалах зардлыг тус компани өөрийнхөө үйл ажиллагааны зардалд оруулан тооцож байна.

2. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Шохойн чулууны олборлолт, тээвэрлэлт, тэсэлгээ зэрэг төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон.

Үүнд: Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд Гол сөрөг нөлөөллүүд:

- Шохойн чулуу олборлох үйл ажиллагаа болон хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт PM10-аас жижиг хэмжээтэй нарийн ширхэгт тоосонцорын хэмжээ ихсэх

- Элэгдэл эвдрэлд өртсөн газраас салхины нөлөөгөөр тоосжилт үүсэх

- Тэсэлгээ, уурхайд ажиллаж байгаа техник, тоног төхөөрмжөөс үүсэх дуу шуугиан, тоосжилт

- Бага оврын халаалтын зуух, хүнд даацын болон бусад техникээс бохирдуулагч хий үүсэх Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Төслийн хэмжээнд ашиглаж байгаа хатуу хучилттай зам эвдрэх, зам засах зэргээс шалтгаалан шороон зам гарган ашигласнаас агаарт тоосжилт үүсэх

- Шатахуун түгээх станц, тос тосолгооны материалын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас агаарт химийн бодис ууршин тухайн орчны агаарыг бохирдуулах. Усны чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд Гол сөрөг нөлөөлөл:

- Уурхайн олборлолтын явцад шүүрүүлэлтийн усыг шавхсанаас гүний усны түвшин буурах. Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Уурхайн хотхон болон ажилчдын кемпийн бохир ус цэвэрлэх байгууламжийн эвдрэл гэмтэл, технологийн горим алдагдсанаас үүдэн гадаргын

болон газрын доорх усны чанар найрлагад нөлөөлөх.

- Шатахуун түгээх станцын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас хөрсөнд нэвчин уст үеийг бохирдуулах.

- Хаягдал чулуулгийн овоолго дахь хүчил шүлтийн тэнцвэр алдагдаж хүчиллэг урсацын нөлөөгөөр гадаргын болон газрын доорх ус бохирдох.

Хөрсний чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд Гол сөрөг нөлөөлөл:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын хэлбэр төрхөд өөрчлөлт орох.

- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орох. Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс элдэгдэл, эвдрэлд орох.

- Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан хөрс бохирдох.

- Хуурай хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.

- Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах. Ургамлан бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд Гол сөрөг нөлөөлөл:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын ургамлан бүрхэвч устгах.

- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох. Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орж ургамлан бүрхэвчид нөлөөлөх.

- Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан ургамлын ургалтанд нөлөөлөх.

- Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт ургамлын гадаргууд бууснаар фотосинтезийн процессийг багасгаж ургамлын ургалтанд нөлөөлөх Биологийн төрөл зүйлд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд Гол сөрөг

нөлөөлөл:

- Уул уурхай түүнийг дагасан суурьшлын бүсээс тухайн бүс нутгийн амьтан дайжих, дүрвэх.

- Уурхайн хөрс хуулалт, хашаажуулалт зэргээс амьтны амьдрах орчин, идэш тэжээл хязгаарлагдах. Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Тээврийн зам хөндлөн гарах амьтад машинд дайруулах.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хараа голын эргэт талбайд 1500 ширхэг мод тарьсан.

Зураг 2-5 Модны суулгац





Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Үүнд:

- Орон нутагт нийгэм эдийн засгийн хүрээнд Хонгор сум, 2-р багт ахмадын баяр болон хүүхдийн баяраар хамтран ажилласан
- Хараа голын орчимд 1500 гаруй модыг тарьц суулгсан.
- Төслийн уурхайн талбайд 300 ширхэг хайлаас мод тарьсан
- Байгаль хамгаалах ажлын хүрээнд ан амьтныг хужир, марай өгөх ажилд оролцсон.

3.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авах арга хэмжээ

| # | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ төг | Нийт зардал төг | Хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|---|------------------------------------|-------------|---|------------------------|----------------------|--|------------------------|--|------------------------------------|
| 1 | Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх | Ил уурхай | м³/сар | Жил бүр | 4 000 000 | Мөнхболор Эрдэнэ ХХК | | - | Шаардлагатай нөхцөлд усалгаа хийгдсэн байх | Агаарын тухай хууль, MNS 4585:2007 |
| 2 | Уурхайн технологийн замын засвар үйлчилгээг тогтмол хийж үүсэх тоосжилтын хэмжээг бага байлгах | | м³ | | Өдөр бүр | | | Үйлдвэрлэлийн зардлаас | - | |
| 3 | Уурхайн тээврийн машины хурдны хязгаарт хяналт тавьж, үүсэх тоосыг бага байлгах | | - | Машин хурд тогтоосон хязгаараас хэтрээгүй байх. | | | | | | |
| 4 | Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг ханган тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хийг үйлдвэрлэгчээс гаргасан хэм хэмжээнд байлгах | Төслийн талбайн хөнгөн тэрэгнүүд | ширхэг | 10 | Үйлдвэрлэлийн зардлаас | Байгаль орчны баг | Улсын үзлэгт хамрагдаж Холбогдох төлбөрийг төлсөн байх | АТ Хууль АБТТ Хууль | | |
| 5 | Гадаад тээврийн замын арчилгааг байнга хийж байх | уурхайгаас Засмал зам хүртэл зам | 80 км | Тухай бүр | Үйлдвэрлэлийн зардлаас | Байгаль орчны баг | Шороон замаар тээвэр хийсэн тохиолдол гараагүй байх | БОХТ Хууль | | |
| 6 | Агаарын тоосжилт буюу PM2.5, 10 хэмжигч 1 цэг байршуулах | Уурхайн хүрээ болон нөлөөллийн бүс | ш | 1 | 5 000 000 | | | | | |

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авах арга хэмжээ
Хүснэгт 2 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авах арга хэмжээ

| # | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ төг | Нийт зардал төг | Хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|--|------------------------------------|-------------|------------|------------------------------------|------------------------|--|------------------------|---|--------------------------------------|
| 1 | Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих, асаргалт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах арга хэмжээ авч ажиллана. | Төслийн талбай | удаа | 12 | 100000 | 1200000 | Байгаль орчны баг | Төслийн нэгжүүд | Хөрсний шинжилгээний дүн стандартын шаардлага хангаж байх | ХХЦСТ Хууль, MNS 5850:2008 |
| 2 | Салаа зам үүсэхээс хяналт тавьж, хөрсний элэгдэл эвдрэл үүсэхээс урьдчилан сэргийлнэ | Төслийн талбай | хүн/өдөр | 12 | 100000 | 1200000 | Байгаль орчны баг | Төслийн нэгжүүд | Төслийн нөлөөллөөр салаа зам гараагүй байх | ХХЦСТ Хууль, ГТХууль |
| 3 | Хөрсний төлөв байдал ба бохирдлын мониторинг судалгаа хийж хэрэгжүүлэх | Уурхайн орчмын бүс | Удаа | 2 | Орчны хяналт шинжилгээний зардлаас | | Байгаль орчны баг | Мэргэжлийн байгууллага | Шинжилгээний дүн, Тайлан гарсан байх | БОНБҮТХ MNS 5850:2008, MNS 3297:1991 |
| 4 | Үер болон борооны усаар зөөгдөн элдэв хог хаягдал хөрсөнд шингээгдэхээс сэргийлж үерийн ус зайлуулах суваг, шуудуу байгуулах | Төслийн талбай болон түүний орчимд | - | - | - | Үйлдвэрлэлийн зардлаас | Уулын үйлдвэрлэлийн хэсэг, байгаль орчны баг | Төслийн нэгжүүд | Үйлчлэлийн нөлөөгөөр | |

3.3 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНОО ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ


Биологийн нөхөн сэргээлтийн туршилтын талбайг бий болгох “Мөнхболор-Эрдэнэ” ХХК, болон дүйцүүлэн хамгаалалт хийхээр сонгосон талбайн нэн ховор болон ховор, унаган ургамлуудыг уурхайн биологийн нөхөн сэргээлтийн туршилтын талбайг бий болгож шилжүүлэн суулгах, үрээр үржүүлэх зэргээр тарималжуулан биологийн нөхөн сэргээлтэнд ашиглах хэрэгтэй. Туршилтын талбайг үржүүлгийн хэсэг, эх ургамалын хэсэг, хүлэмж, бойжуулах талбай, хамгаалалтын зурвас, мод, сөөгний туршилтын хэсэг болон олон наст ургамлын туршилт гэсэн хэсгүүдтэй байж болно. Туршилтын хэсгээс гадна үр, мөчир үрслүүлэх, бордоо, бууц нөөцлөх хэсэг болон үндсэн бэлтгэл ажлын талбайг байгуулах. Туршилтын талбайд тарьж болох ургамлууд Хайлаас, жигд, сухай, улиас, нарс, гацуур, монос, чацаргана, бургас, заг, агч, далан хальс, голт бор, хармаг, хотир, шар хуайс, харгана, гүйлс, буйлс, үхрийн нүд, нохойн хошуу, орог тэсэг зэрэг мод сөөг, бутлаг ургамалууд болон хялгана, өлөнгө, хиаг, ерхөг зэрэг олон наст өвслөг ургамалуудыг тарьж болно.

- Туршилтын талбайд таримал олон наст үетэн угамлууд болох согоовор, ерхөг, нөмрөг ургамал болох овъёос, бударганы үрийг турших тарих.

- Мөн орон нутгийн нэг болон олон наст, сөөг ургамлуудыг үрээр болон ургал эрхтнийг шилжүүлэн суулгах байдлаар тариалах Ногоон байгууламж нь ариун цэвэр, гоо сайхны үнэлж баршгүй ач холбогдолтой бөгөөд агаарын бохирдол, таагүй нөхцлийг бууруулж хүний тохь тухтай, эрүүл амьдрах орчныг бүрдүүлдэг байна. Мод сөөг нь орчныг тоос шорооноос цэвэрлэх байгалийн шүүлтүүр болдог. Агаарын бохирдлоос хамгаалах, тоосыг өөртөө шингээх чадамж нь зуны улиралд 30%, өвөл 37% болохыг судлаачид тогтоожээ. Зөвхөн нэг ширхэг хайлаас ургалтын хугацаандаа 28 кг тоос шороог өөртөө шингээдэг бол нэг га талбайн ой мод цагт 200 хүний амьсгалаар гарсан нүүрсхүчлийн хийг шингээж, 2500 тн ус ууршуулж агаарыг чийглэг зөөлөн болгодог байна. Талбай сонгож, холимог шороо бэлтгэх Сонголт хийсэн талбайн хотгор, гүдгэрийг тэгшилж цэвэрлэх, хөрсийг хүрзээр гишгэж зөөллөх зэргээр дараагийн ажилд бэлтгэнэ. Суулгах мод сөөгний биологийн онцлог, өсөлт хөгжилтийн чадавхид тохируулан хоорондын зай хэмжээг тогтоож суулгах нүхийг ухна. Нүхний өнгөн хэсгийн

ашиглаж болохоор үржил шимт шороог шигшиж ургамлын үндэс, чулуу бусад хольцоос цэвэрлэж дараа хэрэглэхээр овоолж нөөцөлнө. Хайрга, чулуу, шавар зэргийг талбайн тэгшлэх, усалгааны тогоо хийх зэрэгт ашиглаж илүүдлийг хог хаягдлын хамт зөөж зайлуулна. Тус талбай нь үржил шим муутай хад чулуурхаг газарт байрлах тул тусгайлан шимт холимог шороо зохиомлоор бэлтгэн ашиглах шаардлагатай гэж үзэж байна. Олдоц элбэг, үнэ хямдыг бодож өнжмөл бууц (хонины хөх бууц бол бүр ч илүү), аргал хөрзөнгийн үнс, бүдүүн ширхэгтэй элс зэргийг тодорхой харьцаагаар хольж холимог шороог бэлтгэх боломжтой. Мод, бут суулгах нэг нүхэнд 5-8 кг хонины хөх бууц, 4-6 кг бүдүүн ширхэгтэй элс орохоор тооцож, шигшиж нөөцөлсөн хөрсний өнгөн хэсгийн шороотой хольж холимог шороо бэлтгэнэ. Үүнд 2-3 кг аргал хөрзөнгийн үнс нэмж холих нь зүйтэй. Эдгээрийг сайтар хольж хүрэлцэх хэмжээгээр бэлтгэх нь мод бут тарих цаашдын ажилд ихээхэн дөхөмтэй байх болно. Мод сөөг суулгах нүх ухах Мод сөөгийг ургуулахад нэг анхаарах зүйл бол суулгах нүхийг зөв ухаж бэлтгэх явдал байдаг. Мод сөөгний төрөл зүйлийн онцлогоос хамааран суулгах нүхний голч, гүн зэрэг нь янз бүр байдаг.


Зураг 4 тарилт хийх зөвлөмж



Хөрсний ус-чийгийн нөөц, шинж чанар¹ Хөрс нь өөртөө тодорхой хэмжээний ус чийгийг агуулж байдаг. Хөрсөн дэх хими, физик, биологийн ихэнх процессууд усны оролцоотойгоор явагддаг. Хөрсний ус чийгийн нөөц нь ургамал ургах гол нөхцөл болохоос гадна гадаргын болон газар доорх усны нөөцөнд шууд нөлөөлнө. Дэлхийн гадаргын усны нөөцийн багагүй хэмжээ хөрсөнд агуулагддаг. Эрдэмтдийн тооцоогоор далай тэнгис, цас мөсний усыг оролцуулахгүйгээр

дэлхийн гадарга орчмын усны нөөцийн 12.2 % хөрсөнд (67.4 % нуур, 9.5 % агаар, 8.5 % хамгархаг газар, 1.6 % гол, 0.8 % ургамал амьтанд) байдаг байна (Shiklomanov & Rodda, 2003). Уур амьсгалын дулаарал хуурайшилт эрчимжиж усны хомсдол бий болж буй өнөөгийн нөхцөлд хөрсний ус чийгийн нөөцийг хамгаалах зөв зохистой ашиглах асуудал чухал болж байна.

Зураг 5 Хөрсний ус чийгийн нөөцийг хамгаалах зөв зохистой ашиглалт



3.4 ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим Тус компанийн хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь дараах байдлаар тодорхойлогдоно.

Зураг 6 Хог хаягдлын менежмент



Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

Төслийн хүрээнд хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх зорилгоор дараах дотоод журмуудыг даган мөрддөг.

- Хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журам

- Аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах журам

Хог хаягдлыг зайлуулах, устгах арга зам Хог хаягдлын ангилан ялгалт

Хог хаягдлын менежментийг үр ашигтай явуулахад хог хаягдлын ангилан ялгалт нэн чухал бөгөөд хаягдлыг зайлуулах тохиромжтой зөв арга замыг тогтоож өгдөг.

Ангилан ялгалтыг хог хаягдлыг эх үүсвэр дээр ба хог хаягдлыг хүлээн авах нэгдсэн цэг дээр явуулдаг. Эх үүсвэр дээрх хог

Хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор эргүүлж ашиглах зарчмыг баримтлан хог хаягдлыг зүй зохистой удирдан зохицуулахыг зорьж ажилладаг. Хог хаягдлын цэгийн хашааг засаж НААГазартай 2024 оны 04 сарын 1-нд гэрээ хийж, технологийн болон ахуйн хог хаягдлаа сард 2-3 удаа тогтмол ачуулж, орчны эрүүл ахуйн байдлыг ханган ажилласан. Нийт ажилчдыг хог хаягдлын талаар сургалт явуулсан байна.

Хог хаягдлын талаарх сургалт

Хүснэгт 3 Хог хаягдлын сургалтын хуваарь

| № | Нэр | Хамрагдах хүрээ | Хичээл ийн цаг | Хичээл заах багшийн нэр |
|---|--|-----------------|----------------|-------------------------|
| 1 | Хог хаягдалтай холбоотой зөрчлын тухай хуулиас | Ний ажилчид | 1 1 1 | Байгаль орчны ажилтан |
| 3 | Энгийн хог хаягдал ба аюултай хог хаягдлын тухай ойлголт | Нийт ажилчид | | |
| 4 | Хог хаягдлыг багасгах алхам | Нийт ажилчид | | |
| | | Нийт | 3 | |

Зураг 7-8 Хог хаягдлын сургалтын материал


Хог хаягдал байгаль орчинд үзүүлэх нөлөө

✓ Ил задгай хаясан хог хаягдал нь ялзарч муудах, шатах зэргээс шалтгаалан нян бактери үржих, хорт хий ялгарах, үнс, тоосжилт үүсэх гэх мэт хүрээлэн буй орчны хөрс, ус, агаарыг бохирдуулах



✓ Хоол хүнсний хаягдал нь задарч, микро организм өсөж үржих таатай орчныг бүрдүүлэн, халдвар тархах голомт болохоос гадна тэнд цугларсан шавьж, мэрэгч нь халдвар тараагч болно

✓ Хог хаягдлаас үүсэх хүлэмжийн хий нь дэлхийн дулааралд нөлөөлөх бөгөөд озоны цоорлыг нэмэгдүүлэх



Хог хаягдлаас хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

➢ Зохицуулалтгүй хаясан хог хаягдал нь хөрс, гадаргын болон гүний ус, агаарыг бохирдуулан халдварт өвчин тархах (амьсгалын замын болон гэдэсний халдварт өвчин)



➢ Хоол хүнсний хог хаягдал нь задарч, нян бактери өсөж халдвар тараах, шавьж мэрэгч үржиж халдварт өвчин тархах

➢ Аюултай хог хаягдлыг бусад хог хаягдалтай хамт хаяснаас түүнд агуулагдах химийн бодис нөлөөгөөр олон төрлийн өвчин үүсэх



➢ Хуванцар сав, гялгар уутны шаталтаар үүсэх хорт бодис, органик бохирдуулагч нь хорт хавдар, дээд мэдрэл, дотоод шүүрэл, дархлаа, нөхөн үржихүйд нөлөөлөхөөс гадна хүний биед биохимитлал үүсгэх

Зураг 9—10 Хог хаягдлын ангилал

Зарим бүтээгдэхүүн, материалын байгальд шингэж алга болох хугацаа

| | | | | |
|-----------------------------------|--|---|--|---|
| <p>Шил</p> <p>4000 жил</p> | <p>Хуванцар аяга</p> <p>1000 жил</p> | <p>Хуванцар карт</p> <p>1000 жил</p> | <p>Нэг удаагийн аяга таваг</p> <p>500 жил</p> | <p>Хуванцар сав</p> <p>400 жил</p> |
| <p>Лааз</p> <p>10 жил</p> | <p>Хөнгөн цагаан сав</p> <p>100 жил</p> | <p>Асаагуур</p> <p>100 жил</p> | <p>Тамхины иш</p> <p>2 жил</p> | <p>Цаас</p> <p>3 сар</p> |

3.5 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Уурын зуухны орчинд агаарын шинжилгээг тодорхойлоход стандарт хэмжээнээс давсан тохиолдолд илэрсэнгүй. ДУА-ын УЦУОШТөвтэй хамтран тоосны шинжилгээг хийлгэсэн болно.

Шинжилгээний бичиг хавсаргав.

Зураг 11 Шинжилгээний дүн



Зураг 12-13 Орчны шинжилгээний хэмжилт хийж байгаа нь



3.6 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ

БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 4 Оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

| # | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа | Тайлан мэдээлэл хүлээн авах тал | Тайлагнах хэлбэр | Тайлагнах огноо | Нийт зардал мян.төг | Хэрэгжүү - лэгч | Хамтран хэрэгжүү -лэгч | Биелэлтийн шалгуур |
|---|--|---|--|--------------------------|---------------------|-----------------------|-------------------------------|--|
| 1 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан | БОАЖЯам, Аймгийн БО-ны газар, Сумын байгаль орчны ажилтан | Бичгээр | 11 сарын 01-нд | - | "Иннова Ложистик" ХХК | - | Аймгийн БО-ны газраар дүгнэлт гаргасан, тайлан дүгнэлтийн хамт БОАЖЯ-д хүргэгдсэн байна. |
| 2 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хагас жилийн тайлан | Аймгийн БО-ны газар, Сумын байгаль орчны ажилтан | Бичгээр | 07 сарын 20-ны дотор | - | | - | Холбогдох газарт тайлан хүргэгдсэн байна. |
| 3 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн сар бүрийн хэмжилтийн мэдээлэл | Компанийн удирдлагууд | И-мэйл | Сар бүрийн эхний 5 хоног | - | | - | Холбогдох талд сар бүр тайлан хүргэгдсэн байна. |
| 4 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сар бүрийн биелэлт, БО-ны багийн үйл ажиллагааны тайлан | Компанийн удирдлагууд | И-мэйл | Сар бүрийн эхний 5 хоног | - | | - | Холбогдох талд сар бүр тайлан хүргэгдсэн байна. |
| 5 | Нөлөөллийн бүсийн иргэдийг Байгаль орчны мониторингийн ажилд оролцуулах, хэмжилтийн мэдээлэл танилцуулах | 1-р багийн иргэд | Танхимын мэдээлэл ба хээрийн хэмжилтэнд оролцуулах | 10 сарын 20 | - | | Орон нутгийн харилцаа -ны баг | Жилд 1 удаа зохион байгуулагдсан байна. |

Дээрхи хуваарийн дагуу уурхайн орчим амьдрагч айлуудад болон холбогдох байгууллагат тайлангаа хуваарийн дагуу тайлагнасан болно.

Зураг 14-15 БОМТайланг тайлагнаж байгаа байдал



БОМТ-НИЙ ТАЙЛАНГИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Манай компаний байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан мөн тухай онд төлөвлөсөн менежментийн төлөвлөгөөний дагуу уурхайн үйлдвэрлэлийн ажил явагдаж байгаа хэсгүүдэд хийгдсэн байгаль орчныг хамгаалах ажил болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийг дараах байдлаар дүгнэж байна.

2024 онд хийсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг дор дурьдаж байна.

Үүнд:

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийг нэмэх болон тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2000ш мод тарихаас манай компани нь 1500 гаруй ширхэг бургас болон хайлаас модыг тарьсан.
- Байгаль орчны менежментийн хүрээнд хяналтын цэгүүдийг тогтоож хагас жилд нэг удаа дээжлэлт хийж байх тогтсон цэгүүдтэй болсон. Үүнд: Агаар, хөрсний шинжилгээг Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төвийн лабораториор хийсэн болно. Шинжилгээний үзүүлэлтүүд стандарт хэмжээнээс давсан тохиолдолгүй байна.
- 2024 онд орон нутгийн татварт ус, газар, хог хаягдлын төлбөрийг хугацаанд нь төлсөн байна.
- Ан амьтны идэш тэжээлд зориулсан жужир марай тавьж өгсөн.
- Заагдсан хугацаанд тайлангаа орон нутгийн иргэд болон холбогдох байгууллагат хугацаанд нь тайлагнасан болно

Эцэст нь дүгнэхэд Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө болон байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг манай компани нь 95%-ийн биелэлттэй хийж гүйцэтгэсэн гэж дүгнээд цаашид БОННУ-д тусгагдсаны дагуу жил бүр тайлан төлөвлөгөөг хугацаанд нь тайлагнаж дүгнүүлэн ажиллах болно.

